## “ХААН СОЁМБО АУДИТ- ХХК

# САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Их Уул сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2025/198/НА-СТА-ТШ3**


Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Л.Мөнх-Оргил
Утас: 99039344 Цахим хаяг: munkhorgill@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Гүйцэтгэсэн аудитор: Н.Ган-эрдэнэ
Утас: 88115349 Цахим хаяг: ganerdene1083@yahoo.com



Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2025 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/246

танай ____________-ны № ____________-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИХ-УУЛ СУМЫН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
С.ТАЙВАНЖАРГАЛ ТАНАА

## Хараат бус аудиторын дүгнэлт

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд 9,355.5 мянган төгрөгийн бараа материал, 22,792.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар төсвийн зарцуулалт, худалдан авалт, хууль тогтоомжийн биелэлттэй холбоотой 9,236.7 мянган төгрөгийн зөрчил 6 зөрчил илрүүлж, илэрсэн зөрчилд үндэслэн 6 зөвлөмж өгсөн.

### Бусад асуудлын хэсэг

Их-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал нь 2024 онд аймгийн Боловсролын газрын даргатай гэрээ байгуулан ажиллаж, хэрэгжилтийг 91.8 хувийн гүйцэтгэлтэй биелүүлсэн гэж үнэлсэн байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллэс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

- Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **184,736,755.98** | **230,442,771.72** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 105,405,326.98 | 125,346,502.72 |
| **312** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | 105,405,326.98 | 125,346,502.72 |
| **3121** | **Төгрөг** | 105,405,326.98 | 125,346,502.72 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 105,405,326.98 | 125,346,502.72 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 79,331,429.00 | 105,096,269.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 1,125,850.00 | 1,125,850.00 |
| 35130 | Эм боох материал | 1,125,850.00 | 1,125,850.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 78,205,579.00 | 103,970,419.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 558,000.00 | 780,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,232,580.00 | 1,911,580.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,450,000.00 | 1,450,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 78,000.00 | 78,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 9,477,030.00 | 13,416,970.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 65,409,969.00 | 86,333,869.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,288,567,066.16** | **1,278,143,413.58** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,288,567,066.16 | 1,278,143,413.58 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,276,804,066.08 | 1,266,407,913.48 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,326,888,049.00 | 1,326,888,049.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -103,280,609.40 | -122,886,619.20 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 78,480,138.08 | 101,998,133.08 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -42,110,526.18 | -53,026,721.34 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 28,641,800.30 | 29,641,800.30 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -16,825,500.74 | -20,446,051.22 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 19,653,325.00 | 10,285,230.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -18,333,800.98 | -9,737,098.14 |
| 39217 | Ном | 3,691,191.00 | 3,691,191.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 11,763,000.08 | 11,735,500.10 |
| 39301 | Программ хангамж | 275,000.00 | 275,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -109,999.92 | -137,499.90 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 11,598,000.00 | 11,598,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,473,303,822.14** | **1,508,586,185.30** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **760,112.00** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 760,112.00 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 760,112.00 | 00.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 760,112.00 | 00.00 |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,472,543,710.14** | **1,508,586,185.30** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,472,543,710.14 | 1,508,586,185.30 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 71,342,040.30 | 71,342,040.30 |
| 51101 | Өмч: - төрийн | 71,342,040.30 | 71,342,040.30 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,379,326,847.60 | 1,415,369,322.76 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,379,326,847.60 | 1,379,326,847.60 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 36,042,475.16 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 21,874,822.24 | 21,874,822.24 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,473,303,822.14** | **1,508,586,185.30** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **408,288,700.00** | **1,037,785,595.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **32,147,995.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 32,147,995.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 00.00 | 9,355,500.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 00.00 | 9,355,500.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **408,288,700.00** | **1,005,637,600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 360,255,400.00 | 921,967,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 360,255,400.00 | 921,967,400.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 48,033,300.00 | 83,670,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 48,033,300.00 | 83,670,200.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **341,948,974.24** | **1,001,743,119.84** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **341,948,974.24** | **1,001,743,119.84** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 341,948,974.24 | 993,819,719.84 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 205,833,204.52 | 697,884,755.90 |
| 210101 | Үндсэн цалин | 140,514,386.82 | 468,293,551.97 |
| 210102 | Нэмэгдэл | 53,406,919.70 | 219,171,403.93 |
| 210104 | Урамшуулал | 11,911,898.00 | 10,419,800.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 25,657,692.56 | 86,108,726.36 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,495,822.42 | 59,428,749.40 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,058,332.06 | 6,991,617.51 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,646,665.55 | 3,650,788.14 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 405,169.93 | 3,191,652.76 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,051,702.60 | 12,845,918.55 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 42,508,852.60 | 78,670,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,062,025.60 | 8,717,392.45 |
| 210302 | Түлш, халаалт | 37,783,251.00 | 67,170,224.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 663,576.00 | 2,782,583.55 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,167,786.16 | 6,601,880.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 927,500.00 | 533,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 734,300.00 | 2,239,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 00.00 | 842,380.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,837,830.16 | 2,987,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 2,668,156.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 30,031,550.00 | 70,256,260.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 403,100.00 | 00.00 |
| 210502 | Хоол, хүнс | 29,628,450.00 | 70,256,260.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 678,000.00 | 5,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 678,000.00 | 5,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 480,000.00 | 5,535,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 3,438,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 1,152,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 480,000.00 | 945,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 30,591,888.40 | 43,762,097.58 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 699,600.00 | 2,798,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 870,000.00 | 6,021,950.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 29,022,288.40 | 34,941,647.58 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 00.00 | 7,923,400.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 7,923,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 7,923,400.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **66,339,725.76** | **36,042,475.16** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **66,339,725.76** | **36,042,475.16** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл** | 71,342,040.30 | 25,920,708.24 | 11,665,557.89 | 108,928,306.43 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **71,342,040.30** | **25,920,708.24** | **11,665,557.89** | 108,928,306.43 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 21,295,290.94 | 21,295,290.94 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл** | **71,342,040.30** | **21,874,822.24** | **1,379,326,847.60** | 1,472,543,710.14 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл** | **71,342,040.30** | **21,874,822.24** | **1,379,326,847.60** | 1,472,543,710.14 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **71,342,040.30** | **21,874,822.24** | **1,379,326,847.60** | 1,472,543,710.14 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 36,042,475.16 | 36,042,475.16 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл** | **71,342,040.30** | **21,874,822.24** | **1,415,369,322.76** | 1,508,586,185.30 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **780,302,900.00** | **1,005,637,600.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **780,302,900.00** | **1,005,637,600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 697,632,700.00 | 921,967,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 697,132,700.00 | 921,967,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | 500,000.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 82,670,200.00 | 83,670,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 82,670,200.00 | 83,670,200.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **675,090,781.02** | **983,970,924.26** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **675,090,781.02** | **983,970,924.26** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **674,990,710.19** | **976,047,524.26** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 454,403,909.61 | 698,644,867.90 |
| 210101 | Үндсэн цалин | 322,739,185.60 | 469,053,663.97 |
| 210102 | Нэмэгдэл | 109,695,951.49 | 219,171,403.93 |
| 210104 | Урамшуулал | 21,968,772.52 | 10,419,800.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 56,782,671.41 | 86,108,726.36 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 38,727,257.54 | 59,428,749.40 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,544,519.72 | 6,991,617.51 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,635,615.69 | 3,650,788.14 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 897,751.99 | 3,191,652.76 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,977,526.47 | 12,845,918.55 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 77,570,129.17 | 78,670,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,200,649.17 | 8,717,392.45 |
| 210302 | Түлш, халаалт | 67,170,224.00 | 67,170,224.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,199,256.00 | 2,782,583.55 |
| **2105** | **Нормативт зардал** | 56,774,900.00 | 74,196,200.00 |
| 210502 | Хоол, хүнс | 56,774,900.00 | 74,196,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,279,900.00 | 945,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,279,900.00 | 945,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 23,179,200.00 | 32,482,530.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,339,600.00 | 24,559,130.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,839,600.00 | 7,923,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **100,070.83** | **7,923,400.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 7,923,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 7,923,400.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 100,070.83 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 100,070.83 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **105,212,118.98** | **21,666,675.74** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **1,725,500.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **1,725,500.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 1,725,500.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 1,725,500.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-1,725,500.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 105,212,118.98 | 19,941,175.74 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 193,208.00 | 105,405,326.98 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 105,405,326.98 | 125,346,502.72 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Улсын төсвийн гүйцэтгэл:

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 105,405,326.98 | (105,405,326.98) | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,027,033,300.00 | 902,026,224.26 | 125,007,075.74 | 87.83 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 1,027,033,300.00 | 902,026,224.26 | 125,007,075.74 | 87.83 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 1,019,109,900.00 | 894,102,824.26 | 125,007,075.74 | 87.73 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 803,472,000.00 | 698,644,867.90 | 104,827,132.10 | 86.95 |
| 210101 | Үндсэн цалин | 553,034,700.00 | 469,053,663.97 | 83,981,036.03 | 84.81 |
| 210102 | Нэмэгдэл | 238,948,800.00 | 219,171,403.93 | 19,777,396.07 | 91.72 |
| 210104 | Урамшуулал | 11,488,500.00 | 10,419,800.00 | 1,068,700.00 | 90.70 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 92,630,900.00 | 86,108,726.36 | 6,522,173.64 | 92.96 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 62,991,100.00 | 59,428,749.40 | 3,562,350.60 | 94.34 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,408,500.00 | 6,991,617.51 | 416,882.49 | 94.37 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 3,705,100.00 | 3,650,788.14 | 54,311.86 | 98.53 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,705,100.00 | 3,191,652.76 | 513,447.24 | 86.14 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,821,100.00 | 12,845,918.55 | 1,975,181.45 | 86.67 |
| 2105 | Нормативт зардал | 82,350,700.00 | 74,196,200.00 | 8,154,500.00 | 90.10 |
| 210502 | Хоол, хүнс | 82,350,700.00 | 74,196,200.00 | 8,154,500.00 | 90.10 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 2,689,400.00 | 945,000.00 | 1,744,400.00 | 35.14 |
| 210806 | Мэдээллийн технологийн зардал | 2,689,400.00 | 945,000.00 | 1,744,400.00 | 35.14 |
| 2201 | Бараа үйлчилгээний бусад зардал | 37,966,900.00 | 34,208,030.00 | 3,758,870.00 | 90.10 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,043,500.00 | 26,284,630.00 | 3,758,870.00 | 87.49 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,923,400.00 | 7,923,400.00 | - | 100.00 |
| | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 7,923,400.00 | 7,923,400.00 | - | 100.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 7,923,400.00 | 7,923,400.00 | - | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 7,923,400.00 | 7,923,400.00 | - | 100.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 936,152,800.00 | 921,967,400.00 | 14,185,400.00 | 98.48 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 894,823,200.00 | 921,967,400.00 | (27,144,200.00) | 103.03 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 894,823,200.00 | 921,967,400.00 | (27,144,200.00) | 103.03 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 41,329,600.00 | - | 41,329,600.00 | - |
| 1200041 | Үндсан үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 140,000.00 | - | 140,000.00 | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 41,189,600.00 | - | 41,189,600.00 | - |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 105,405,326.98 | (105,405,326.98) | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 125,346,502.72 | (125,346,502.72) | - |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | - | - |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - | - | - |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 27.00 | 27.00 | - | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 14.00 | 14.00 | - | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 12.00 | 12.00 | - | 100.00 |

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 83,670,200.00 | 83,670,200.00 | - | 100.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 83,670,200.00 | 83,670,200.00 | - | 100.00 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 83,670,200.00 | 83,670,200.00 | - | 100.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 78,670,200.00 | 78,670,200.00 | - | 100.00 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 8,000,000.00 | 8,717,392.45 | (717,392.45) | 108.97 |
| 210302 | Түлш, халаалт | 68,170,200.00 | 67,170,224.00 | 999,976.00 | 98.53 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,500,000.00 | 2,782,583.55 | (282,583.55) | 111.30 |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 5,000,000.00 | 5,000,000.00 | - | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,000,000.00 | 5,000,000.00 | - | 100.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 83,670,200.00 | 83,670,200.00 | - | 100.00 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 83,670,200.00 | 83,670,200.00 | - | 100.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 83,670,200.00 | 83,670,200.00 | - | 100.00 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | (0.00) | 0.00 | - |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | - | - |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - | - | - |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 27.00 | 27.00 | - | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 14.00 | 14.00 | - | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 12.00 | 12.00 | - | 100.00 |

## 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар үндсэн хөрөнгө, бараа материал, төсвийн зарцуулалттай холбоотой 11 зөрчил илрүүлж 4 залруулга, 6 зөвлөмж, 1 албан шаардлага, хүргүүлсэн.

### 5.1 Аудитын залруулга

1. Сорлог Хангай ХХК-аас нийлүүлсэн бага 2 бүлгийн дрожийг бусад хангамжийн материалд бүртгэсэн нь бараа материалын үлдэгдлийг өсгөж байна. Үндсэн хөрөнгөнд бүртгэх

### 5.2 Төлбөрийн акт

1. Төлбөрийн акт тогтоогоогүй

### 5.3 Албан шаардлага

1. албан шаардлага тоо

### 5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой

*Илрүүлэлт:*

Эрхлэгчийн "Балансын урамшуулал олгох тухай" 2024 оны Б-12 дугаар тушаалаар нягтлан бодогчид 2 сар, няравт 1 сараар тус тус тооцож олгохдоо ажлын үр дүнг үнэлээгүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23.2-т "Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудыг урамшуулахдаа ажлын үр дүнг бодитой тооцож, улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулахгүй байхад анхаарч ажиллах

2. Зардлын данстай холбоотой

*Илрүүлэлт:*

Төсвийн захирагч нь 6 багш ажилтанд нийт 44,253.2 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл олгох шийдвэрийг гаргахдаа нэмэгдэл хөлс тооцож олгох батлагдсан маягтыг хөтлөөгүй байна. Энэ нь Засгийн газрын "Журам батлах тухай" 382 дугаар тогтоолын 4 дэх заалтыг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Илүү цагийн нэмэгдэл олгох шийдвэрийг гаргахдаа нэмэгдэл хөлс тооцож олгох батлагдсан маягтыг хөтлөх

3. Зардлын данстай холбоотой

Илрүүлэлт:

Тус цэцэрлэг өөрийн ажил үйлчилгээний онцлогт нийцүүлэн автомашины шатахуун зарцуулалтын жишиг нормыг тогтоогоогүй, жолоочийн тооцооны хуудсыг хөтлөхдөө спидометрийн заалтыг бичээгүй, багш, ажилтанд 2,239.1 мянган төгрөгийн шатахууныг жолоочийн тооцоо бодолгүйгээр зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “Хариуцлагатай байх” 6 дугаар зүйлийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." Батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Автомашины шатахуун зарцуулалтын жишиг нормыг тогтоож, жолоочийн тооцооны хуудсанд спидометрийн заалтыг оруулж, шатахууныг нормоор зарцуулах

4. *Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой*

*Илрүүлэлт:*

Ур чадварын нэмэгдлийг холбогдох журмын дагуу багш нарын ур чадварыг үнэлэх ажлын хэсэг байгуулж, ажлыг үнэлсэн баримтгүйгээр төсөв захирагчийн 5 удаагийн тушаалаар 28 багш, ажилтанд нийт 20,024.6 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл хөлс олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3.1.*"төсвийн захирагч нь төсөвт зохицуулалт хийх саналаа харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаггүй бол төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх"* гэсэнтэй нийцэхгүй байгаа ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Ур чадварыг захирлын тушаалаар багш, ажилтанг үнэлэх баг байгуулан хагас жил бүр үр дүнг тооцон ажиллах.

5. *Ахмадын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой*

*Илрүүлэлт:*

Тус байгууллага нь Ахмадын тухай хуулийн холбогдох заалтын дагуу ахмадын сан байгуулж, жилийн төсөвтөө төлөвлөж батлуулаагүй байна. Энэ нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална", Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-тай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Ахмадын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хууль журмын дагуу байгууллагын төсвийн төсөлдөө ахмадын санг төлөвлөн батлуулж ажиллах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргаж, fas.audit.mn системд оруулж, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

*/Мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Илүү цагийн нэмэгдэл олгосон | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| Ажлын үр дүнг үнэлэлгүй илүү цагийн нэмэгдэл олгосон | 1 | 3,887.0 | | | | | 1 | 3,984.0 |
| Шатахууны норм тогтоогоогүй | 1 | 2,339.1 | | | | | 1 | 2,339.1 |
| Дотоод хяналтын ажлын тайланг дутуу тайлагнасан | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| **Дүн** | **4** | **6,226.1** | | | | | **3** | **6,226.1** |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| | | | | | | | | |
| Дүн | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Худалдан авах ажиллагааны мэдээллийг хугацаа хоцорч оруулсан , худалдан авалтын гэрээнд заасан нэр төрөл, тоо хэмжээгээр нийлүүлэлт хийгээгүй байна. | 1 | 0 | | | 1 | 0 | | |
| | 1 | 6,897.6 | | | 1 | 6,897.6 | | |
| Ахмадын тухай хуулийн дагуу ахмадын сан байгуулж ажиллаагүй. | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| Дүн | 3 | 6,897.6 | | | 2 | 6,897.6 | 1 | 0 |
| Нийт дүн | 3 | 6,897.6 | | | 2 | 6,897.6 | 1 | 0 |